



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 02 өдөр


Дугаар 1/250

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/07 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, иргэд олон нийтэд үзүүлэх үйлчилгээг ойртуулах, нэг цэгээс авах боломжийг бүрдүүлэх зорилгоор байгуулах “Үйлчилгээний нэгдсэн төвийн 3D зураг зурах” ажилд зориулан 1,900,000 төгрөгийг зарцуулсугай.
2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 1,900,000 төгрөг (нэг сая есөн зуун мянга)-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн жагсаалтын 4.7-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт тус тус зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГ  Б. ДҮГЭРЖАВ